

ТА БНЧУ-Д ОРОН БАЙР ХАЙЖ БАЙНА УУ?

Иргэн бүр Чех улсад орон сууц хайх боломжтой, эсвэл байгууллага, үл хөдлөх хөрөнгийн агентлагийн үйлчилгээг ашиглах боломжтой. Хэрэв та үл хөдлөх хөрөнгийн агентлагтай холбоо барьж, тэдний үйлчилгээг ашиглах бол өөр өөр түвшинтэй бөгөөд төлбөртэй гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй.

Юуг анхаарах вэ?

Ямар орон байр байх вэ? Орон байранд орсны дараа та түрээслэгч эсвэл давхар түрээслэгчийн аль нь болох уу? Та түрээсийн эсвэл давхар түрээсийн гэрээний алийг нь байгуулах вэ?

- **Түрээсийн гэрээ** – түрээсийн гэрээг эзэмшигч ба түрээслэгчийн хооронд бичгээр байгуулсан баримт юм (энгийнээр хэлбэл, энэ баримт бичгийн ачаар та орон сууц/байшинг ашиглах эрхтэй болно).
- **Давхар түрээсийн гэрээ** – түрээслэгч болон давхар түрээслэгчийн хооронд бичигдсэн баримт бичиг юм. Энэ нь түрээслэгч өөрийн ашиглаж байгаа орон байр/байшинг гуравдагч этгээдэд түрээслэх нөхцөл юм - давхар түрээслэгч.
 - Хэрэв та давхар түрээслэгчээр тухайн байранд амьдардаг бөгөөд ОАМР-д өөрийн гэрийн хаягаа нотлох баримтыг бүрдүүлэхдээ, давхар түрээсний гэрээнээс гадна түрээсийн гэрээг нэмнэ (орон байрны эзэмшигч ба түрээслэгчийн хооронд; энэ нь түрээслэгч дараагийн өөр хүнд түрээслэж болохыг тодруулахын тулд).

Та барьцаа/урьдчилгаа төлбөр төлөх ёстой юу? Энэ нь түрээслэгчтэй, давхар түрээсийн гэрээ байгуулсан тохиолдолд танаас авах хураамж юм.


- Төлбөр нь ихэвчлэн 3 түрээс байдаг.
- Байрны барьцааны төлбөрийг бичгээр баримтжуулсан байх ёстой.
- Барьцааны мөнгө буцаан олгох боломжтой. Энэ нь хэрэв та нүүхийг хүсвэл барьцааг тань буцааж өгөх ёстой. Гэсэн хэдий ч нотлогдсон өрийг (жишээлбэл: түрээсийн төлбөр, ус, байранд хохирол учруулахад гм.) үүнээс суутгаж болно.

Орон сууц амьдрах үед СӨХ-ийн болон бусад ашигласан төлбөрүүдийг сар бүр тогтмол төлнө:

- түрээс,
- концессын төлбөр (телевиз, радиогийн төлбөр),
- эрчим хүчний хэрэглээний урьдчилгаа төлбөр (цахилгаан, хий),
- орон сууц, байшинг ашиглахтай холбоотой үйлчилгээний урьдчилгаа төлбөр (ус, орцны нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ болон гэрэлтүүлэг, хотын хог хаягдлыг мөнгө - зарим хотод үүнийг төлдөггүй, магадгүй цахилгаан шат болон бусад урьдчилгаа төлбөрүүд).



- ОЙЛГОХГҮЙ ЗҮЙЛДЭЭ ХЭЗЭЭ БҮҮ ГАРЫН ҮСЭГ ЗУР.
- ТА ГЭРЭЭГЭЭ ҮРГЭЛЖ ХАДГАЛЖ МӨН ХЭНД Ч БҮҮ ӨГ.
- ХААНА Ч БАЙСАН ӨӨРИЙН ОРШИН СУУГАА ЗӨВ ХАЯГАА МЭДЭГДЭХ ХЭРЭГТЭЙ!
Оршин суугаа хаягийн өөрчлөлтийг заасан хугацаанд, цаг тухайд нь мэдэгдэх ёстой.
- ОРШИН СУУХ ХАЯГИЙН ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ БОЛОН ХОНХ НЬ ДЭЭР ӨӨРИЙН НЭРИЙГ ТЭМДЭГЛЭХ ШААРДЛАГАТАЙ.
Хэрэв энэ боломжгүй бол бид мэдээллийн хайрцаг үүсгэхийг зөвлөж байна.



БНЧУ-д амьдрах талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хууднаас авах боломжтой - www.centrumcizincu.cz
(Гадаадын иргэдэд зориулсан үндсэн мэдээллүүд - Оршин суух)



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace
cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financováno OP AMIF a MV ČR.

ТА БНЧУ-Д ОРОН БАЙР ХАЙЖ БАЙНА УУ?



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace
cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financován OP AMIF a MV ČR.